

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТӨСӨЛ НЬ
ДАРААХ БҮТЦИЙН ХҮРЭЭНД БИЧИГДСЭН БАЙХ

1. Төслийн нэр
2. Төслийн байршил
3. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн мэдээлэл:
 - 3.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
 - 3.3. Эрүүл мэндийн байгууллагыг Үүсгэн байгуулагчийн мэдээлэл
 - 3.4. Эрүүл мэндийн байгууллагыг Үүсгэн байгуулагчийн шийдвэр
4. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм /Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйл/. Дүрэмд дараах зүйлийг тусгана.
 - 4.1. байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг;
 - 4.2. удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ;
 - 4.3. санхүүжилтийн эх үүсвэр;
 - 4.4. хөрөнгийн зарцуулалт
5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэл”-тэй нийцэж буй байдал
6. Тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах үндэслэл, зорилго зорилт, Эрүүл мэндийн салбарын өрсөлдөөнд нөлөөлөх байдал
7. Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ижил төрлийн эрүүл мэндийн байгууллагатай харьцуулсан харьцуулалт, тусгай зөвшөөрөл хүсэгчийн давуу байдал, үр ашгийн тооцооллыг, үйлчлэх хүрээний хүн амын тоонд харьцуулан тооцсон байдал
8. Ядуу, эмзэг бүлгийн хүн амд хүрч үйлчлэх байдал
9. Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн дүн, санхүүжилт хийгдэх хугацаа, эх үүсвэр, Төслийн орлого, өртгийн төсөөлөл, түүнтэй уялдуулсан үйлчлүүлэгчээс авах үйлчилгээний төлбөрийн төсөөлөл
10. Төсөл хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх, бүрэн хүчин чадлаараа тогтвортой ажиллах нөхцөлд үйлчлүүлэх хүн амын тооны төсөөлөл, нэг эрүүл мэндийн ажилтанд ногдох үйлчлүүлэгчийн тоо, үйлчилгээний зардал, төлбөрийн хэмжээ бүтээгдэхүүний борлуулалтын үнэ, төсвийг гурван жилээр тооцсон санхүүгийн тооцоолол
11. Холбогдох стандарт, дүрэм журмыг хангаж буй тухай - Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.6- 13.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1, 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын болон Олон улсын стандарт, удирдамж, дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлсон өөрийн байгууллагын үйл ажиллагааны төрөл, мэдээлэл
12. Тусламж үйлчилгээнд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийн жагсаалт, түүний техникийн үзүүлэлт, хүчин чадал, Монгол Улсын болон Олон улсын стандартад нийцсэн байдал
13. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах байгууллагын удирдлага болон хүний нөөцийн мэргэшсэн байдал – иргэний үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, диплом, лицензийн хуулбар
14. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа болон тусгай хог хаягдал, ариутгал, халдваргүйжүүлэлт, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө

15. Барилга байгууламжийн зураг төсөл – Өөрийн эзэмшлийн болон түрээсийн байр эсэх, байрны план зураг